

ТАНИЛЦУУЛГА

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай”
Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно” гэж, Эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Монгол Улсын Их Хурал эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 6.1.1.төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох” гэж заасан байна.

Түүнчлэн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны Зорилт 2.2-ын 2.2.19-д “Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн даатгалын сангаас олгох зардлын ялгааг үе шаттайгаар арилгана.”, 2.2.20-д “Төрийн өмчийн эмнэлгийн санхүүжилтийн болон удирдлагын бие даасан хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.”, 2.2.36-д “Иргэд орчин үеийн эмчилгээ, оношилгооны өндөр өртөгтэй, нарийн төвөгтэй, оношилгоо, эмчилгээ хийлгэх тохиолдолд зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас олгох үйл ажиллагааг өргөжүүлнэ.” 2.2.37-д “Иргэн, даатгуулагч эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээ болох сэргээн засах, сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ авах зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжийг бүрдүүлнэ.” гэжээ.

Монгол Улсын Засгийн газраас эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог сайжруулах, эрүүл мэндийн тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх зорилгоор хуваагдмал эх үүсвэрүүдийг нэгтгэх, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжих, стратегийн худалдан авалтыг хийх, төрийн эрүүл мэндийн байгууллагуудыг гарц, үр дүнд суурилсан санхүүжилтэд шилжүүлэх, төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлэг, нэгдсэн эмнэлгүүдийг хагас бие даалгахад чиглэсэн хууль эрх зүйн багц өөрчлөлтийг өргөн мэдүүлснээр Улсын Их Хурлаас Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд 2020 оны 08 дугаар сарын 28-ний өдөр нэмэлт, өөрчлөлтийг оруулж, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Санхүүжилтийн шинэчлэлийн хууль, эрх зүйн өөрчлөлтүүдийн хүрээнд улсын төсвөөс улсын эмнэлгүүдэд “эдийн засгийн ангиллаар” хуваарилдаг байсан 496 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сан руу шилжүүлж, төлбөрийн арга, журам, зарчмыг нэг болгож Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь нэг худалдан авагч болж стратегийн худалдан авалтыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн.

Дээрх шинэчлэлийн үр дүнд 2021 оноос өмнө нэг иргэн жилд 2.0 сая төгрөгт багтах тусламж, үйлчилгээ авах боломжтой байсан бол стратегийн худалдан авалт буюу нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр 2.0 сая төгрөгөөс дээш төгрөгт багтах тусламж, үйлчилгээг 2021 онд 17754 иргэн авсан.

2024 онд 142207 болж 8 дахин нэмэгдсэн байна. Мөн 2020 онд нийт хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан тохиолдлын тоо 18.3 сая байсан бол 2024 онд 26.3 сая болж 43.7 хувиар нэмэгджээ.

Хэдийгээр хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн, санхүүгийн хамгаалалт сайжирсан, төрийн эмнэлгүүд гүйцэтгэлээрээ санхүүжих боломж бүрдсэн ч Эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцэл алдагдаж хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг цаашид хэвийн санхүүжүүлэх, түүнчлэн иргэдийг хувийн төлбөрөөс үүдсэн санхүүгийн эрсдэлээс сэргийлэхэд хүндрэл үүсэж, төрийн эмнэлгүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлт нөхцөл байдал бий болоод байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт тус тус заасныг үндэслэн эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлсэн стратегийн худалдан авалтын үйл ажиллагаанд Улсын Их Хурлаас хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол зохион байгуулах, иргэд олон нийтийг мэдээллээр хангах, шаардлагатай арга хэмжээг авах зорилгоор Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Хянан шалгах түр хороо байгуулах саналыг гаргасан тул "Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлсэн стратегийн худалдан авалтын нөхцөл байдал, гүйцэтгэлийн санхүүжилтийн үр дагаварт бий болсон асуудлыг тодорхойлох зорилгоор холбогдох тогтоол, шийдвэр, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх" үүрэг бүхий хянан шалгах түр хороо байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөлд хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг "Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлсэн стратегийн худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх" гэж, хүрээ хязгаарыг дараах байдлаар тогтоохоор тусгасан болно. Үүнд:

1/ Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн асуудлыг зохицуулж буй бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт;

2/ Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцдаг тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ бүхий төрийн эрүүл мэндийн байгууллагуудын 2022-2025 оны санхүүгийн удирдлага болон эмнэлгийн хагас бие даасан байдлыг хангах үйл ажиллагаа.